



ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн зөвлөлөөс эрхлэн гаргав.

2022 оны Дөрөвдүгээр сар
Цуврал №3

МОНГОЛ УЛС ДАХЬ ИНФЛЯЦЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОН ДЕФОЛТЫН ЭРСДЭЛ

АСУУДАЛ | НӨХЦӨЛ БАЙДАЛ | ШААРДЛАГАТАЙ АЛХМУУД



НИЙТИЙН ТӨСӨВ, САН ХӨМРӨГИЙГ УДИРДАХАД
ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭН БҮР МЭДЭЭЛЭЛТЭЙ
ОРОЛЦОЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЭРХТЭЙ.



ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ

Төрийн төсөв, санхүүд тавих хяналтыг сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төсвийн Зөвлөл”-ийг Нээлттэй Нийгэм Форумгаас санаачлан 2021 оны 3 дугаар сард байгуулсан юм. Төсвийн Зөвлөл нь хараат бус шинжээчдээс бүрдэж буй бөгөөд иргэд нийтийн төсөв, сан хөмрөгийг удирдахад мэдээлэлтэй оролцох, хяналт тавих боломж нөхцөлийг бүрдүүлэх үндсэн дээр нийтийн сан хөмрөгийн оновчтой зарцуулалтыг дэмжих зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Н.Энхбаяр, Эдийн засагч

Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол Улс дахь менежер А.Батпүрэв, “Санхүүгийн хүртээмж-хөгжил” ТББ-ын Үүсгэн байгуулагч, гишүүн

С.Боргил, Санхүүч, “Сэргэлт Консалтинг Групп” компанийн захирал

Г.Бумчимэг, Банк Санхүүгийн Академийн Гүйцэтгэх захирал

Ц.Мөнхбаяр, Эдийн засагч, санхүүч, Байэр Адвайзори ХХК-ийн зөвлөх

Ч.Нарантуяа, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

П.Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

Д.Оюунбадам, Төсвийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн Зөвлөл (цаашид Төсвийн зөвлөл гэх) нь улсын санхүү, төсвийн асуудлаар тогтмол хуралдаж, хэлэлцүүлгийн дүнг бодлогын шинжилгээ болгон эрхлэн гаргаж байна. Төсвийн зөвлөл нь ээлжит хэлэлцүүлгээ “Монгол Улс дахь инфляцын нөхцөл байдал болон дефолтын эрсдэл” сэдвээр 2022 оны 4 дүгээр сард хийлээ. Энэ удаагийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудыг Зөвлөлийн гишүүн С.Боргил нэгтгэв.

АСУУДАЛ

Дэлхийн нийтээр 2020 оноос хойш Ковид-19-ын цар тахлаас шалтгаалан улс хоорондын бараа бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэлтийн тасалдал, үйлдвэрлэлийн бууралттай нүүр тулж эдийн засгийн өсөлт дийлэнх улсуудын хувьд удааширч, хумигдсаар байна. Дэлхийн олон улс оронд цар тахлын сөрөг нөлөөлөл арилаагүй, эдийн засаг бүрэн сэргэж амжаагүй энэ үед саяхны Орос Украины мөргөлдөөнөөс үүдсэн эрчим хүч, хүнсний хямрал нь шинэ төрлийн сөрөг нөлөөллийг улс орнуудын нийгэм, эдийн засгийн орчинд бий болгож байна. Олон улсын валютын сан (ОУВС)-ын мэдээлснээр үүссэн нөхцөл байдал нь хөгжиж байгаа орнуудыг дефолтын эрсдэлд оруулж байгаа бөгөөд орлого багатай орнуудын 60% нь өрийн хямралтай тулаад байна.¹ Ковид болон олон улсын хэмжээний хямралаас үүдэн 2022 онд Шри Ланк улсад хүнс, түлш шатахууны хомсдолд орж жилийн инфляц 21.5 хувьд хүрч эдийн засгийн гүнзгий хямрал нүүрлэн 51 тэрбум ам.долларын гадаад өрийн төлбөр дээрээ дефолт зарласан. Аргентин улсын жилийн инфляц 52 хувьд хүрч 2022 болон 2023 онд төлөх нийт 39 тэрбум ам. долларын гадаад өрийн төлбөр дээр дефолтын эрсдэл үүссэний улмаас тус улсын сенат дахин санхүүжилтийн хувилбарыг баталж ОУВС руу хүсэлтээ хүргүүлээд байна. Мөн Пакистан улс санхүүгийн хүндрэлийн улмаас ОУВС-тай

¹ Vitor Gaspar, Director of the IMF's Fiscal Affairs Department, and Ceyla Pazarbasioglu, the Organisation's Strategy Chief, Aljazeera, April 12, 2022

яриа хэлцэл хийж эхлээд байна. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын таамаглаж байгаагаар өнөөдөр үүсээд байгаа таагүй нөхцөл байдлуудын улмаас цаашид дампуурч болзошгүй улс орны тоо нэгээр тогтохгүй гэж үзсэн.

Монгол Улсын хувьд 2020 оноос эхэлсэн цар тахлаас үүдсэн нийлүүлэлтийн тасалдал нь эдийн засаг, нийгмийн олон тулгамдсан асуудлыг авчирч хил гаалийн саатал, тээвэрлэлтээс шалтгаалан импортын болон хэрэглээний барааны үнэ өссөөр байна. Үнийн өсөлт Орос Украины мөргөлдөөнөөс улбаалан улам эрчимжиж хамгийн сүүлийн байдлаар жилийн инфляц 14.2² хувьд хүрлээ. Мөргөлдөөнөөс шууд шалтгаалан дэлхийг хамарсан эрчим хүч, хүнсний хямрал эхэлсэн бөгөөд энэхүү хямралт байдал энэ онд намжих нь тодорхойгүй зэргээс хамааран манай улсын хувьд гадаад хүчин зүйлээс

хамаарсан инфляц цаашид өсөхөөр байна. Мөн БНХАУ-ын зүгээс хэрэгжүүлж байгаа “Тэг ковид” бодлого нь Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудад хүчтэй нөлөөлөх ба үүн дотроо Монгол Улсын хувьд -0.38 орчим нэгж хувиар нөлөө үзүүлэхээр байгаа талаар³ Дэлхийн Банк тайландаа дурджээ. Гадаад нөхцөл байдал, сөрөг нөлөөлөл нь манай экспортыг хумихаас гадна импортын тасалдал үргэлжилж инфляцыг цаашид өсгөх нь тодорхой. Үүнээс гадна инфляцаар дамжин нийгэм, эдийн засгийн бүх салбарт цочрол, дарамт ирэх нь дамжиггүй. Иймд Нээлттэй нийгэм форумын дэргэдэх Төсвийн зөвлөл (цаашид Төсвийн зөвлөл гэх)-өөс Монгол Улс дахь инфляц болон түүнээс улбаалсан дефолтын эрсдэлийн талаар хэлэлцүүлэг хийж, уг хэлэлцүүлгийн үр дүнг энэхүү тайланд танилцуулж байна.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Манай улсын инфляцын гадаад шалтгаан, нөлөөллийг дараах байдлаар зураглаж байна. Үүнд:

- Олон улсын хэмжээнд шинээр үүссэн нөхцөл байдал (ОХУ-Украины мөргөлдөөн, БНХАУ-ын “Тэг-КОВИД”, дэлхийн нийтийг хамарсан инфляц)
- Олон улсын зах зээл дээрх хүнсний болон нефтийн үнийн өсөлт
- Олон улс дахь тээвэр логистикийн саатал, хилийн хязгаарлалтууд
- Хилийн хязгаарлалтаас улбаатай тээврийн нэмэлт зардал (Монголбанкны мэдээгээр

тээврийн зардал 2022 оны 3 дугаар сарын байдлаар 2020 оноос 3-4 дахин өндөр хэвээр байна⁴)

- Нийлүүлэлтийн сүлжээний доголдол (БНХАУ-ын Ковидын эсрэг бодлоготой холбоотойгоор үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт хязгаарлагдсан)
- Гадаад инфляц (Худалдааны түнш орнуудын үнийн өсөлт, “КОВИД-19” цар тахлаас шалтгаалан агшсан дэлхийн эдийн засаг 2021 онд хурдтай сэргэж нийлүүлэлтээс давсан эрэлтийг үүсгэсэн нь дэлхий нийтээр инфляцыг эрчимжүүллээ,

² Үндэсний Статистикийн Хороо, 2022 оны 2 дугаар сарын мэдээ

³ Braving the storm, World Bank, April 2022

⁴ Инфляцын тайлан, Монголбанк, 2022 оны 3 сар

мөн олон улсад тээвэр логистикийн саатал бий болсноор тээврийн зардал өсөх, нийлүүлэлт тасалдах зэргээр зардлын шалтгаантайгаар инфляц нэмэгдэх нөлөөг үзүүлж байна⁵).

Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээс харахад нийт инфляцын 50 орчим хувь нь импортын инфляц байгаа нь дээрх нөхцөл шалтгаануудыг тодорхой хэмжээгээр баталж байна. Одоогоор инфляцын үзүүлэх нөлөөлөл нь хэрэглээний барааны үнийн өсөлт, тээвэрлэлт, үйлдвэрлэлийн зардлын өсөлт, гадаад валютын хомсдолоор илэрч байгаа боловч урт хугацаандаа аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа хумигдах, ажилгүйдэл өсөх, ядуурал нэмэгдэх зэрэг олон эрсдэлт нөхцөл байдал үүснэ.

Монгол Улс хуулийн зохицуулалт болон төсөв мөнгөний бодлогоор дамжуулан инфляцын нөлөөллийн эсрэг дараах арга хэмжээг авч байна. Үүнд:

- **УИХ-аас “Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль баталсан.** Хуулийн дагуу газрын тосны бүтээгдэхүүн, гурил, мах гэсэн гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлнэ.
- **Засгийн газраас төсвийн хумих бодлого явуулна.** Энэ хүрээнд зарим зүйлийн зардлыг бууруулж төсвийн орлогын дахин төсөөлөл дээр үндэслэн 2022 оны төсөвт тодотгол хийсэн. Мөн төсвийн зардлыг бууруулах, хэмнэх зорилго бүхий Төрийн хэмнэлтийн тухай хуулийг төслийг УИХ-д хэлэлцүүлэхээр оруулсан.

- **Төв банк бодлогын хүүгээ өсгөсөн.** Мөнгөний нийлүүлэлтээр дамжуулан инфляцыг бууруулах үүднээс Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2022 оны 3 дугаар сард бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 9.0 хувьд хүргэх шийдвэр гаргасан. Мөн шинээр батлагдсан үнийн өсөлтийн хуулийн дагуу Монгол банк дээрх 3 бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөц бүрдүүлэхэд шаардлагатай хөнгөлөлттэй санхүүжилтийг арилжааны банкаар дамжуулан олгох; алтны худалдан авалтыг нэмэгдүүлэх; санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан эдгээр 3 бүтээгдэхүүний импортын төлбөрийн гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах; алт олборлогч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгох; алт худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар гадаад валютын улсын нөөцийг өсгөх гэсэн арга хэмжээ авна.
- **Арилжааны банкнууд валютын гүйлгээнд хязгаарлалт тавьсан.** Энэ хязгаарлалтын дагуу төгрөгөөр валют худалдан авахад хэмжээ тогтоосон нь валютын хомсдолд орохоос сэргийлэх нөгөө талаар ханшийн өсөлтөөр дамжин инфляц хөөрөгдөх явдлыг хаах оролдлого юм.

Засгийн газрын хувьд инфляцын нөлөөллийг бууруулах нь нэн тэргүүний зорилт боловч авах арга хэмжээнүүд нь дийлэнхдээ дотоодод үүсэж байгаа асуудлуудыг намжаахад чиглэсэн харин импортоос хамаарсан инфляцад нөлөөлөлгүй байна. Манай импортын орц үйлдвэрлэлд дунджаар 35%-40% байгаа нь нэг талаар импортын орц тал дээрээ бид нар асуудлаа шийдээгүй байгаа нөгөө талаар дэд бүтэц гээд олон асуудал байгаа учраас

⁵ Инфляцын тайлан, Монголбанк, 2022 оны 3 сар

импортын гаралтай бүтээгдэхүүний инфляцыг бид жолоодож чадахгүй юм⁶.

Инфляцтай зэрэгцээд манайд гарч байгаа нөгөө гол асуудал нь гадаад өрийн төлбөрийн асуудал юм. Одоогоор дефолт зарласан болон зарлах эрсдэл өндөртэй орнуудад гарч байгаа нийтлэг урьтал нөхцөл нь тухайн улс орнуудын инфляц болоод байгааг энд зориуд тэмдэглэх нь зүйтэй. Манай улсын хувьд Засгийн газрын өр 2021 оны байдлаар 33 их наяд төгрөг (10.9 тэрбум ам.доллар) болж өссөн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 79.5⁷ хувьд хүрсэн байна. Засгийн газрын өрийн дүнд Монгол банкны Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцэл (ойролцоогоор 1.6 тэрбум ам.доллар) болон Хөгжлийн банкны гадаад бондыг (ойролцоогоор 700 сая ам.доллар) нэмж тооцоход энэ нь ДНБ-ний 96 хувьд хүрч байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Хөгжлийн банкны 2016-2023 онуудаар тооцсон гадаад эх үүсвэрийн эргэн төлөлтийн нийт хэмжээ 6,736.2 тэрбум⁸ төгрөг болж байна. Эдгээр эх үүсвэрүүдээс ирэх онд нийт 2,275 тэрбум төгрөгийн (Европын сэргэн мандалт бонд 500 сая ам.доллар, Самурай бонд 725 тэрбум төгрөг) гадаад өрийн төлбөр төлөх хуваарьтай. Зээлийн эх үүсвэрүүдийг Хөгжлийн банкаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд олгосон боловч өнөөгийн байдлаар 40 гаруй аж ахуйн нэгжийн нийт 2.1 их наяд⁹ төгрөгийн зээл чанаргүй ангилалд орсон байна. Зээлийн эргэн төлөлт хангалтгүй тохиолдолд эх үүсвэр нь төсвөөс гарах талаар Засгийн газрын хуралдаан дээр Сангийн сайд мэдээлсэн байна¹⁰.

ЗУРАГ 1. ГОЛЛОХ ГАДААД БОНДУУДЫГ ЭРГЭН ТӨЛӨХ ХУВААРЬ (САЯ АМ.ДОЛЛАР)



Эх сурвалж: СЯ; Монголбанк; Дэлхийн банкны тооцоолол.

Гэтэл төсвийн орлогын 30 орчим хувийг, экспортын 90 хувийг бүрдүүлж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нь дараах бодит нөхцөлүүдээс шалтгаалан тасалдах, төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл ихтэй байна. Үүнд:

- Гол худалдан авагч БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч ирэх онд агшина;
- БНХАУ-ын “Тэг ковид” бодлогын улмаас хил гаалийн нэвтрэлт хүндрэлтэй хэвээр байгаа;
- Дэлхийн нийтээр инфляцын улмаас бараа бүтээгдэхүүний эрэлт багасаж БНХАУ-ын үйлдвэрлэл удааширч эхэлсэн.

Иймд дээр дурдсан хянах боломжгүй гадаад нөхцөл байдлаас шалтгаалан ирэх 2023 онд төлөх 1.3 тэрбум ам.долларын гадаад өрийн төлбөрт (Зураг 1) дефолтын эрсдэл үүсэж болзошгүй хэмээн Төсвийн зөвлөлийн зүгээс үзэж байна.

⁶ Н.Энхбаяр, Төсвийн зөвлөлийн гишүүн

⁷ Монгол Улсын эдийн засгийн тойм, Дэлхийн банк, 2022 он 4 сар

⁸ Хөгжлийн банканд хийсэн шалгалтын ажлын тайлан, 2016 он

⁹ Сангийн сайд Б. Жавхлан, 2022 оны 5 сарын 8, <https://news.mn/r/2553826/>

¹⁰ <https://ubn.mn/p/27351>

ШААРДЛАГАТАЙ АЛХМУУД

Дэлхий нийтэд үүсээд байгаа цар тахлын дараах эдийн засгийн хямралт байдал, нийлүүлэлтийн тасалдал, Орос Украины мөргөлдөөнөөс үүдсэн эрчим хүч, хүнсний хямрал зэрэг хянах боломжгүй гадаад нөхцөлөөс хамаарсан дотоодын эдийн засгийн төлөвийн талаарх хувилбарууд дээр үндэслэн дефолтоос урьдчилан сэргийлэх алхам, арга хэмжээг Төсвийн Зөвлөлөөс боловсрууллаа.

Хувилбаруудад гадаад нөхцөл байдал 2023 оныг дуустал одоогийнхоос дээрдэж сайжрахгүй гэж төсөөлж дотоодын эдийн засаг, нийгэм дэх гарч болох эрсдэлт нөхцөлүүд дефолтод хэрхэн нөлөөлж болохыг харуулахыг зорилоо. Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний

үнэ болон нийлүүлэлтийн боломжит хослол дээр үндэслэн дөрвөн төрлийн хувилбарыг төсөөлөлд суурь болгон ашиглалаа. Боломжит хослолд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ цаашид одоогийн түвшинд хэвээр хадгалагдана эсвэл буурна гэж таамагласан. Хувилбаруудад экспортын гадаад хүчин зүйл, экспортын орлого, инфляц, нийгэм улс төр, төсөв гэсэн үндсэн үзүүлэлтүүдийг ашигласан болно. Одоогийн байгаа нөхцөл дээр үндэслэн инфляц цаашид буурахгүй өснө эсвэл өнөөгийн түвшинд хадгалагдана гэж тооцсон. Мөн Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлт бүрэн хийгдэхгүйгээр уг банкинд дээр байгаа гадаад бондын төлбөрийг төсөв хариуцна гэж төсөөлсөн.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВИЙН ХУВИЛБАРУУД БА ДЕФОЛТЫН ЭРСДЭЛ

Үндсэн үзүүлэлтүүд	Хувилбар 1: Уул уурхайн бүтээгдэхүүний: -үнэ хэвээр -нийлүүлэлт ↑	Хувилбар 2: Уул уурхайн бүтээгдэхүүний: -үнэ хэвээр -нийлүүлэлт ↓	Хувилбар 3: Уул уурхайн бүтээгдэхүүний: -үнэ ↓ -нийлүүлэлт ↑	Хувилбар 4: Уул уурхайн бүтээгдэхүүний: -үнэ ↓ -нийлүүлэлт ↓
Гадаад хүчин зүйл	Хил гааль, тээвэрлэлтийн нөхцөл одоогийн түвшинд хадгалагдаж, эрэлт өөрчлөгдөхгүй	Хил гааль, тээвэрлэлтийн нөхцөл муудсан эсвэл эрэлт унасан	Хил гааль, тээвэрлэлтийн нөхцөл хэвийн боловч худалдан авагчийн зүгээс хямд үнэ тулгах эсвэл дэлхийн зах зээл дээрх үнэ унана	Хил гааль, тээвэрлэлтийн нөхцөл муудсан эсвэл эрэлт унасан, мөн үнэ буурсан
Экспортын орлого	Экспортын орлого одоогийн төлөвлөснөөр орно	Экспортын орлого одоогийн түвшнээс багасна	Экспортын орлогыг одоогийн түвшинд бариулах хэмжээний олборлолт хийж тээвэрлэх боломжгүй учраас орлого буурна	Экспортын орлого эрс багасна

Инфляцын нөхцөл байдал	Инфляц эрчимтэй өсөхгүй	Экспортын орлого буурснаас үүдэн гадаад валютын ханшийн өсөлт гарч инфляц хөөрөгдөнө	Экспортын орлого буурснаас үүдэн гадаад валютын ханшийн өсөлт гарч инфляц хөөрөгдөнө	Гадаад валютын ханшийн өсөлт эрчимжиж инфляц гаарна
Нийгэм, улс төрийн нөхцөл байдал	Нийгэм, улс төрийн нөхцөл төдийлөн муудахгүй	Нийгэм, улс төрийн нөхцөл тогтворгүй болно, ядуурал нэмэгдэнэ	Нийгэм, улс төрийн нөхцөл тогтворгүй болно, ядуурал нэмэгдэнэ	Нийгэм, улс төрийн нөхцөл маш тогтворгүй болно, ядуурал нэмэгдэнэ
Улсын төсөв	Улсын төсвийн орлого төлөвлөснөөс буурахгүй	Улсын төсөвт экспортын орлогын бууралттай холбоотой төсвийн орлогын тасалдал үүснэ, ядуурлаас үүдэн халамжийн арга хэмжээг ихээр санхүүжүүлнэ	Улсын төсөвт экспортын орлогын бууралттай холбоотой төсвийн орлогын тасалдал үүснэ, ядуурлаас үүдэн халамжийн арга хэмжээг ихээр санхүүжүүлнэ	Улсын төсвийн алдагдал өснө, ядуурлаас үүдэн халамжийн болон хүндрэлтэй байдлыг түр намжаах арга хэмжээг ихээр санхүүжүүлнэ
НЭГДСЭН ДҮР ЗУРАГ	Хөгжлийн банкны гадаад бондын төлбөрөөс шалтгаалж дефолтын эрсдэл арилахгүй	Төсвийн байдал хүндэрч дефолтын эрсдэл ихэснэ	Төсвийн байдал хүндэрч дефолтын эрсдэл ихэснэ	Төсвийн байдал хүндэрч алдагдал санхүүжүүлэхэд эх үүсвэр шаардлагатай болно, дефолтын эрсдэл бүр ихэснэ.

Дээрх хувилбаруудаас Монгол Улсад дефолт үүсэх эрсдэл нь бодитой гэж үзэж дефолт үүсэхгүй байх чиглэлд бодлого боловсруулагчдын зүгээс авах арга хэмжээ, хийх алхмуудыг дараах байдлаар томъёоллоо. Үүнд:

- Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх (зээлийн барьцаат хөрөнгийг нэн яаралтай зарж борлуулах, зарим зээлийн багцыг бусад арилжааны банкнуудад хямдруулан зарах гэх мэт);
- Гадаад өрийн төлбөрийг хугацааг хойшлуулах, сунгах талаар зээлдүүлэгчидтэй хэлцлүүдийг эхлүүлэх (debt restructuring);
- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас авах нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр, зээл авах, тусгай хөтөлбөрт хамрагдах талаарх яриа хэлцлийг эхлэх;
- Гадаад өрийн төлбөрт нэмэлт санхүүжилт, эх үүсвэр шаардлагатай гэж үзвэл олон улсын зах зээл дээр шинээр нэмж үнэт цаас, бонд гаргах үйл ажиллагааг эхлүүлэх;
- Гадаад өр төлбөрийг зэс болон нүүрсээр төлөх бололцоог судлах (ялангуяа Хятадын Ардын Банктай байгуулсан своп дээр сунгагдахгүй байх эрсдэл үүснэ гэж тооцвол);

- Дефолтын эрсдэл үүсэхэд төсвөөс шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээ болон төсвийн гэнэтийн зарлагын өсөлтийг (улс төрийн тогтворгүй байдал, инфляцаас шалтгаалсан ядуурлаас үүдэлтэй) тооцсон 2023 оны улсын төсвийн хувилбарыг боловсруулах;
- Монгол улсын эдийн засаг, санхүүгийн байдал ирэх сар, улиралд сайжрах эсхүл муудах эсэх нь үндсэндээ ганцхан улсаас буюу БНХАУ-ын төр засгийн зүгээс гаргах шийдвэрээс л шууд хамаарах өндөр эрсдэлтэй байна. Мөн энэ оны 7-р сард эцэслэн гарах ОУВС-ын ажлын хэсгийн тайланд нааштай дүгнэлт тусгагдахгүй гэдэг нь тодорхой болсон. Иймд өндөр эрсдэлтэй, гадаад зах зээлээс шууд хамаарч буй нөхцөлд цаашид нөхцөл байдал сайжирна гэсэн өөдрөг төсөөлөлд хэт найдалгүйгээр, ирэх оны төсвийн төслийг эцэслэн боловсруулахаас өмнө Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч нар ОУВС-д очиж уулзалт хийх шаардлагатай;
- Ирэх 2023 оны төсвийн төслийн үзүүлэлтийг ОУВС-тай урьдчилан сайтар ойлголцож, тохирч байж, уг тохирсон макро үндсэн үзүүлэлтийн хүрээнд багтаан ирэх 2023 оны төсвийн төслийг боловсруулах шаардлагатай болно.



С.Боржил нь 2013 оноос хойш эдийн засаг, банк санхүү, уул уул уурхайн салбаруудад судалгааны ажил хийж байна. Орон нутгийн төсөв, засгийн газрын бонд, төсвийн зарлагын төлөвлөлт, удирдлагын чиглэлээр ажилласан туршлагатай.